



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1993 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А. 274

Улаанбаатар хот


Зах нээн ажиллуулах тухай

1. Барааны болон хүнсний захын ачааллыг багасгах, иргэдэд үйлчлэх хүрээг өргөтгөх зорилгоор "Чингис" ХЭАА-н хүсэлтийг үндэслэн Баянгол дүүргийн 5-р хорооны нутаг "Өнөр" хорооллын "Наран" кафе тушаа замын урд "Комплекс импорт" компаний баруун талд 1,5 га газар дээр хүнс, барааны "Хархорин" зах нээн, үйл ажиллагаанд нь байнга хяналт тавьж ажиллахыг тус дүүргийн Засаг дарга /н.Ганбаатар/-д даалгасугай.

2. Хүнс, барааны "Хархорин" захын захиргаа /н.Лхагвадорж/-нд даалгах нь:

а/Нийслэлийн Засаг даргын 1993 оны А/Г34 тоот захирамжийг мөрдлөг болгон захын хашаан доторхи болон гадна орчны гудамж талбайд ариун цэвэр, тохижилт, нийгмийн дэг журам сахиулах ажлыг хариуцан ажилласугай;

б/Захын ажиллах цагийн хуваарь, үйлчилгээний хураамжийг нийслэл, дүүргийн зохих албадаар хянуулж, цотоод журам боловсруулан мөрдсүрэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

[Signature]

Ц.БААСАНЖАВ